

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ**(Эрүүгийн эрх зүйн маргаан¹)**ШҮҮХ ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХДЭЭ МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬ, ТҮҮНД НИЙЦҮҮЛЭН ГАРГАСАН, АЛБАН ЁСООР
НИЙТЛЭГДСЭН ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭНЭ**

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024/ХШТ2024/97

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж даалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нар дараах гэмт хэрэгт холбогджээ. Үүнд:

- I. Шүүгдэгч М.С нь 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ... улсын дугаартай тээврийн хэрэгслээр гарал үүслийн гэрчилгээгүй модон материал тээвэрлэн явах үедээ түр саатуулсан Замын зохицуулагч цагдаа Ц.Б-д өөрийн үйлдлийг шалгуулахаас зайлсхийх зорилгоор бэлэн мөнгө санал болгож хахууль өгөхийг завдсан;
- II. Шүүгдэгч Д.Б-н хатгаснаар прокурор Т.У, цагдаагийн газрын дарга Д.Г, дэд дарга Т.Б, экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч Б.З, экологийн мөрдөгч Б.О, байцаагч Б.О-т нар үйлдлээр нэгдэн албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж М.С-н гарал үүслийн гэрчилгээгүй модон материал тээвэрлэж явсан дээрх үйлдлийг хэрэг, зөрчлийн бүртгэлд оруулан шалгалгүй явуулж хууль бус давуу байдал бий болгосон;
- III. Шүүгдэгч Д.Г, Д.Э, Д.Эн нар 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 13 цагийн орчимд согтуугаар улсын дугаартай тээврийн хэрэгслийг жолоодож Замын хөдөлгөөнд оролцсон Г.Э-д хариуцлага тооцохгүйгээр явуулж хууль бус давуу байдал бий болгосон гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх** М.С, Б.О, Б.От, Б.З, Т.Б, Т.У, Д.Б, Д.Г, Д.Э, Д.Эн нарт холбогдох хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19

¹ Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3615?daterange=2024-07-03%20-%202024-07-03&id=3&court_cat=2&bb=1



дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1²-д заасан гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатган, хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж шийдвэрлэжээ.

2. **Давж заалдах шатны шүүхээс** Д.Эн, Д.Г нарын үйлдлийг “...аймгийн цагдаагийн газар ажилладаг албан тушаалтнууд нь доод албан тушаалтнуудаа дарамталдаг, ашиг сонирхлыг нь хохироодгийг ил болгосноор авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих талаар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн гэж үзэж болохоор байх тул “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-н ...дүгээр зүйлийн ...-д зааснаар “хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хуульд заасан хууль зүйн хариуцлагад татах үндэслэл болохгүй.” гэх хуулийн үндэслэл байна” гэж дүгнэн цагаатгах тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг³-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Д.Эн, Д.Г нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай гэж заасныг хэвээр үлдээж, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг⁴-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн М.С, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Б.О, Б.От, Б.З, Т.Б, Т.У, Д.Б, Д.Э нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасныг хүчингүй болгосугай” гэж өөрчилж, прокурорын эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэжээ.
3. **Шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч нар хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо:** Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхээс цагаатгаж шийдвэрлэснийг хүчингүй болгосон нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, давж заалдах шатны шүүх хуулийг анхан шатны шүүхээс зөрүүтэй хэрэглэж, нэг магадлалаар өөр өөр зөрүүтэй тайлбар дүгнэлтийг хийж, зарим цагаатгагдсан этгээдэд холбогдсон үйлдэл холбогдлын талаар нэг ч дүгнэлт хийгээгүй атлаа түүнд холбогдох хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаан шийдвэрлэж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй.
4. **Прокурор хяналтын шатны шүүхэд бичсэн эсэргүүцэлдээ:** Анхан шатны шүүх хэргийг бүхэлд нь цагаатгасан байхад цагаатгах тогтоолд өөрчлөлт

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 34.19 дүгээр зүйл. Хэргийг хэрэгсэхгүй болгох. 1.1.гэмт хэргийн шинжгүй.

³ Эрүүгийн хууль (2015)-ийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁴ ЭХ-ийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор бусдад албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан мөнгө, эд зүйл өгсөн, эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн, эсхүл эдгээрийг амласан, санал болгосон бол нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



оруулсан гэж ойлгогдохоор, гэтэл зарим шүүгдэгчийг цагаатгасныг хүчингүй болгосон атлаа дахин хэлэлцэх эсэх нь тодорхойгүй, цагаатгах тогтоол хүчинтэй мэтээр ойлгомжгүйгээр бичигдсэн байна. *Хэргийн үйл баримтын болон хууль хэрэглээний талаарх шүүхийн дүгнэлт нь утга, найруулгын хувьд алдаагүй, ойлгомжтой, тодорхой байхаас гадна холбогдох хуулийн зүйл, заалтыг ягштал баримталсан, түүнийг биелүүлэхэд эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байх ёстой.*

5. Анхан шатны шүүхийн шийдвэр зөрчилтэй бол хүчингүй болгох, эсхүл өөрчлөлт оруулах ёстой. Гэтэл магадлалд аль алиныг нь хэрэглэсэн нь буруу бөгөөд энэхүү шийдвэрийг зөвтгүүлэх нь хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль нь *Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөөгүй /Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдээгүй/ байхад хуулийн төслийг удирдлага болгон дүгнэсэн нь хууль хэрэглээний хувьд илтэд зөрчилтэй, хариуцлагагүй үйлдэл болжээ.*
6. **Хяналтын шатны шүүхээс:** Анхан шатны шүүх нэр бүхий шүүгдэгч нарын үйлдлийг “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэхдээ хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримтуудыг бодит байдлаар нь бүрэн гүйцэд үнэлээгүй, *гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй мэдээлэлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй нөхцөл байдал нь бусдад давуу байдал бий болгосон үйлдэл мөн эсэхэд хууль зүйн дүгнэлт хийхийн оронд уг хэрэг явдлыг хожим шалгаж, шийдвэрлэсэн прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрийг үндэслэн “хууль бус давуу байдал бий болгоогүй” гэж дүгнэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг⁵-т заасныг зөрчсөн байна.*
7. Давж заалдах шатны шүүхээс цагаатгах тогтоолыг хууль ёсны шаардлага хангаагүй гэж үндэслэл бүхий дүгнэлт хийж, *8 шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хүчингүй болгосон нь зөв* болжээ.⁽⁴⁾⁶
8. Харин шүүгдэгч Д.Г, Д.Эн нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс хэвээр үлдээсэн нь хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзэв. (5)
9. Тодруулбал, Д.Г нь гарал үүслийн гэрчилгээгүй модон материал тээвэрлэж явсан үйлдэлд зохих шалгалт явуулахгүй байх хууль бус үүрэг чиглэл өгсөн талаар Т.Б-ын мэдүүлгээс өөр нотлох баримтгүй гэж үзэхдээ прокурорын яллаж буй бусад нотлох баримтуудыг няцаан үгүйсгээгүйн гадна *согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон Г.Э-д шийтгэл оногдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хууль бус давуу байдал эдлүүлсэн хэргийн талаар огт дүгнэлт хийгээгүй байна.*
10. Шүүгдэгч нарын холбогдсон хэрэг нь прокурорын яллах дүгнэлтэд тусгагдсанаар цагдаагийн дээд шатны албан тушаалтны тушаал, даалгаврыг

⁵ ЭХХШТХ-ийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана.

⁶ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



биелүүлсэн шинжтэй, шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо хоорондоо харилцан хамаарал бүхий үйлдэл байхад зарим шүүгдэгчийг цагаатгасан шийдвэрийг хэвээр үлдээж, бусдыг дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй.

11. Мөн *давж заалдах шатны шүүхээс Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн батлаагүй Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг баримтлан шүүгдэгч Д.Эн-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хэвээр үлдээсэн нь Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ” гэж заасныг зөрчсөн ноцтой зөрчлийг гаргажээ.*
12. Иймд дээр дурдсан үндэслэлээр прокурорын бичсэн эсэргүүцлийг хангаж, анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгосон өөрчлөлтийг магадлалд оруулж, цагаатгах тогтоолыг хэвээр үлдээхийг хүссэн шүүгдэгч нар болон тэдгээрийн өмгөөлөгчдөөс гаргасан гомдлуудыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэлээ. (13)
13. Хяналтын шатны шүүхээс дээрх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.